

## ПАТЕНТЫН ЭРХ ЗҮЙ: МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ ОНЦГОЙ ЭРХТЭЙ ЮУ?

## PATENT LAW: IS PATENT APPLICANTS ENTITLED TO EXCLUSIVE RIGHT?

**Б.Одгэрэл**

Дотоод хэргийн их сургуулийн докторант, Оюуны өмчийн газрын ахлах шинжээч

**B.Odgerel**

Ph.D. Candidate of the University of Internal Affairs, Senior patent examiner, Intellectual property office

\*хариуцлагатай зохиогч: Odgerel@ipom.gov.mn

**Хураангуй:** Патентын эрх зүйд патентаар хамгаалагдсан шинэ бүтээлийг өмчлөх онцгой эрх патент эзэмшигчид хадгалагддаг. Мэдүүлгийн шатанд хэвлэгдсэн шинэ бүтээлийг түр хамгаалалтад авч, мэдүүлэг гаргагчийн эрхийг хамгаалах нэг онцлог зохицуулалт 2021 оны 5 дугаар сарын 9-ны өдөр шинэчлэн батлагдсан Патентын хуульд шинээр оржээ. Тус хуулийн 24 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт түр хамгаалах хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр уг шинэ бүтээлийг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглох эрхийг мэдүүлэг гаргагчид олгосон эрх зүйн шинэ зохицуулалт үйлчилж байна. Энэ заалтын дагуу патент олгоогүй, патент олгох эсэх нь тодорхойгүй мэдүүлгийн шатанд хэвлэгдсэн шинэ бүтээлийг түр хамгаалалтад авч, мэдүүлэг гаргагчийн эрхийг хамгаалахаар хуульчилсан нь судалгаа хийх нөхцлийг бүрэлдүүлсэн. Судалгаагаар патентаар олгогдох онцгой эрх эдлэхийн тулд мэдүүлэг гаргагчийн мэдүүлсэн шинэ бүтээл нь патентаар хамгаалагдсан байх, патент эзэмшигч нь патентаар хамгаалагдсан шинэ бүтээлийг өмчлөх онцгой эрхтэй болон тодорхой тохиолдлуудад патент эзэмшигчийн онцгой эрхийг хязгаарладаг болохыг олж тогтоосон бөгөөд үндсэндээ патентын хууль тогтоомж нь мэдүүлэг гаргагчийн эрхийг хамгаалдахад чиглэдэггүй байна.

Энэ өгүүлэлд патентын хуулийн үйлчлэлийн хүрээнд мэдүүлэг гаргагчийн эрхийг хамгаалах асуудлыг хуулиар зохицуулсан эсэх, мэдүүлэг гаргагч шинэ бүтээлийн аливаа ашиглалтыг хориглох эрхтэй эсэх болон түр эрхийн зохицуулалтын талаар голчлон судласан. Энэхүү судалгааны хүрээнд патентын хуульд түр эрхийн зохицуулалтыг хэрэгжүүлэх санал дэвшүүлэхийг зорилоо.

**Abstract:** The patent owner is entitled to exclusive rights to the patented invention in patent law. The revised Patent Law of Mongolia, which was approved on May 9, 2021, provides provisional protection for inventions published in the official gazette until a patent is granted. Article 24.8 of the law provides a new legal regulation that grants patent applicants provisional rights to prohibit any unauthorized use of their inventions throughout the provisional protection period. The study is prompted by the fact that the provision allows the applicant to be granted a provisional right during the publication stages of patent applications where a patent has not been granted or there is uncertainty about whether a patent will be granted for an invention. In this study, we found that in order to enjoy the exclusive rights granted by a patent, the inventions filed by the applicants must be protected by a patent, the patent owners have exclusive right to own their patented inventions, and a number of exceptions applied to the exclusive right. Essentially, patent legislation is not intended to protect the rights of the applicants.

The key objectives of this article are to determine whether the protection of the applicants' rights is regulated by patent law, and whether the applicant has the right to prohibit any unauthorized use of their inventions, and the legal basis for provisional rights. In this context, this article proposes the implementation of provisional rights under patent law.

**Түлхүүр үгс:** патентын мэдүүлэг гаргагч, патентаар олгогдох эрх, онцгой эрхийн хязгаарлалт, түр эрх, эрх зүйн орчин

**Keywords:** patent applicants, exclusive rights, exceptions to exclusive rights, provisional rights, legal background



Дотоод хэргийн их сургууль  
 UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS, MONGOLIA

## Удиртгал

Монгол Улсын Патентын тухай хуулийн үйлчлэх хүрээ “...зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах, патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг ашиглахтай холбогдсон харилцааг...” зохицуулахад чиглэжээ (Патентын тухай хууль, 2021). Энэ хүрээнд тус хуулийн 47.2-т “Патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, эсхүл бүтээгдэхүүний загварыг патент эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бусад этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглахыг хориглоно.” гэж заажээ. Энд патент олгосон тохиолдолд патент эзэмшигчийн эрхийг хамгаалж, патент эзэмшигчид өөрийн шинэ бүтээлээ өмчлөх онцгой эрх олгодог эрх зүйн зохицуулалт үйлчилдэг байна. Энэ зохицуулалтаас гадна Патентын хуулийг 2021 онд шинэчлэн батлахдаа мэдүүлэг гаргагчийн эрхийг хамгаалах нэг онцлог зохицуулалт шинээр оруулсан. Мэдүүлэг гаргагчийн эрхийг тус хуулийн 24.8 дахь хэсэгт түр хамгаалахаар зохицуулжээ. Энэ хэсэгт “албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэгдсэн шинэ бүтээлийг патент олгох хүртэлх хугацаанд түр хамгаалалтад авах бөгөөд энэ хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр уг шинэ бүтээлийг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно” гэж заасан. Энэхүү хуулийн 24 дүгээр зүйлийн тухайд шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэгт хайлт хийх, нийтэд мэдээлэх харилцааг зохицуулсан мэдүүлгийн шатны зохицуулалт байх бөгөөд мэдүүлэгт хайлт хийснийхээ дараа оюуны өмчийн газар хуулийн 24.6-д заасны дагуу патентын мэдүүлгийг нийтэд дэлгэж хэвлэдэг. Мэдүүлгийг хэвлэхтэй зэрэгцээд шинэ бүтээлийг патент олгох хүртэлх хугацаанд түр хамгаалалтад авч, шинэ бүтээлийг мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр ашиглахыг хориглохоор заасан энэхүү зохицуулалт нь хуулийн дээрх үйлчлэх хүрээнээс эхлээд хуулийн бусад бүлэг, зүйл, хэсэг, заалттай зөрчилдөх нөхцөл байдал үүсгэжээ. Тухайлбал хуулийн Долдугаар бүлэгт зохицуулсан патентын

эрх, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах зохицуулалттай зөрчилдөж байна. Энэ бүлэгт зохион бүтээгчийн эрх, патент эзэмшигчийн эрх болон патентаар олгогдох эрхийг хуульчилсан. Түүнээс гадна энэ бүлэгт патентын эрхийг зөрчсөнд тооцохгүй үйлдлүүдийг зааж, патент эзэмшигчийн эрхийг тодорхой тохиолдлуудад хязгаарласан байхад мэдүүлэг гаргагчид дээрх хуулийн заалтын дагуу мэдүүлэг гаргагчийн мэдүүлсэн шинэ бүтээлийг “аливаа хэлбэрээр” ашиглахыг хориглох үнэмлэхүй эрх олгожээ.

Мэдүүлэг гаргагчид олгосон шинэ бүтээлийг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглох эрхийг хангах хууль зүйн үндэслэл бүрдсэн эсэхийг зайлшгүй судлах шаардлага тулгарч байна. Энэ талаарх судалгаа одоогийн байдлаар илрэхгүй байна. Мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр түүний шинэ бүтээлийг ашиглах асуудлыг патентаар олгогдох онцгой эрхийн хүрээнд авч үзэх үндэслэлтэй байна. Энэхүү онцгой эрхийн хүрээнд патентаар хамгаалагдсан шинэ бүтээлийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Хуулийн дээрх хэсэгт “түр хамгаалалт” гэх нэр томьёо шинээр томьёологдсон байгааг мэдүүлэг гаргагчид олгож байгаа түр эрхийн хүрээнд судалж, энэ төрлийн хамгаалалтыг патент эзэмшигчийн эрхийг хуульд заасны дагуу хангах үндсэн зарчмаас өөрөөр зохицуулдаг эсэхийг энэхүү өгүүлэлд нарийвчлан судаллаа.

### Мэдүүлэг гаргагчийн эрх зүйн байдал

Патентын хуулийн үйлчлэх хүрээ өмнө дурдсанчлан зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрхийг хамгаалахад чиглэдэг. Хуульд зохион бүтээгч, патент эзэмшигчийг тодорхойлсноос гадна тэдгээрийн эдлэх эрхийг нарийвчлан заасан бол мэдүүлэг гаргагч, түүний эрхийн талаар тусгайлан зохицуулаагүй байна. Мэдүүлэг гаргагч гэгч ямар субъект болохыг мэдүүлэгтэй холбон авч үзвэл хуулийн 3.1.2-т патентын мэдүүлэг гэдгийг “иргэн, хуулийн этгээдээс энэ хуульд заасны дагуу гаргасан хүсэлт, өргөдөл болон холбогдох бусад баримт бичгийн

бүрдэл" гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолтоос хуулиар тогтоосон тодорхой бүрдэл бүхий патентын мэдүүлгийг оюуны өмчийн газарт гаргах этгээд нь мэдүүлэг гаргагч гэж тодорхойлох боломжтой байна. Хуулийн 16 дугаар зүйлд мэдүүлэг гаргагч нь хувь хүн, хуулийн этгээд байхаар зохицуулснаас өөрөөр зохицуулаагүй байдал илэрч байна. Мэдүүлэг гаргагч нь зохиогч бол баталгаа шаардахгүй, өөр этгээд байх тохиолдолд мэдүүлэг гаргах эрхтэйгээ батлах шаардлагатай байдаг (Намжил, 2000, 88 дахь тал). Эндээс ерөнхийд нь дүгнэхэд мэдүүлэг гаргагчийг оюуны өмчийн газарт патентын мэдүүлэг гаргах, уг мэдүүлэгтэй холбоотой асуудлаар тус газартай харьцах этгээд гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ мэдүүлэг гаргагчид патентын мэдүүлэг гаргах эрхийг олгоогүй байх бөгөөд зөвхөн зохион бүтээгч хүссэн тохиолдолд л түүний өмнөөс мэдүүлэг гаргах боломжтой болдог (Патентын тухай хууль, 2021). Цаашилбал, оюуны өмчийн газарт мэдүүлэг гаргах эсхүл гаргасан патентын мэдүүлгийг холбогдох хууль журамд заасан шаардлага, шалгуурт нийцүүлэх үйл ажиллагааг мэдүүлэг гаргагчид үүрэгжүүлэн хариуцуулжээ.

Гэтэл энэ үүрэгжүүлсэн хэм хэмжээтэй зэрэгцээд мэдүүлэг гаргагчид хуулийн 24.8-д заасны дагуу түүний зөвшөөрөлгүй шинэ бүтээлийг аливаа хэлбэрээр ашиглахыг “хориглох эрх” олгожээ. Хуулийн 24 дүгээр зүйлийн хүрээнд мэдүүлэг гаргагчийн шинэ бүтээлд патент олгох эсэх нь тодорхойгүй байх үе шат байна. Энэ зохицуулалтын хувьд шинэ бүтээлийн мэдүүлэгт хийсэн хайлтын үр дүнг нийтэд зарлаж оюуны өмчийн байгууллагаас албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэхээр зохицуулсан нь уг шинэ бүтээлд патент олгоно гэсэн үг биш байна. Тухайлбал хуулиар зохицуулсны дагуу мэдүүлгийг ингэж хэвлэснээс хойш хэрэв тухайн шинэ бүтээлийн мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх хүсэлт гаргаагүй бол тус мэдүүлэг нь хэвлэгдсэн хэвээр мэдүүлэг чигээрээ үлддэг. Харин тухайн шинэ бүтээлийн мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийлгэх хүсэлт гаргасан бол патент олгох

эсэх мөн чанарын шүүлтэд очино. Хуулийн 25-д заасанчлан ...шинэ бүтээл ... энэ хуулийн 5,6,7 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан эсэхэд мөн чанарын шүүлт хийнэ ... гэж заасны дагуу шүүлт хийж, шалгуур хангасан эсэх шийдвэр гаргана. Шалгуур хангасан патент олгох боломжтой гэсэн шийдвэр гарвал шинэ бүтээлийн ном зүй, томъёолол патентын хэвлэлд нийтэлсэн өдрөөс хойш 3 сарын дотор няцаасан нотолгоо ирээгүй, маргаан гараагүй бол патент олгодог гэх зэрэг хуульд заагдсан олон үйл ажиллагаа шинэ бүтээлийн мэдүүлэгт хийгдэхээр хүлээгдэж буй мэдүүлгийн үе шат ажээ.

Ийнхүү патент олгох эсэх нь тодорхойгүй үе шатанд мэдүүлэг гаргагчийн мэдүүлсэн шинэ бүтээлийг хамгаалж, аливаа ашиглалтыг хориглох эрхийг мэдүүлэг гаргагч эдлэх боломжгүй нөхцөл байдал илэрч байна. Патентын амин сүнс тулгуур ойлголт нь онцгой эрх. Онцгой эрхийг тухайн патент авахаар мэдүүлсэн шинэ бүтээлд патент олгосноор эдлэх боломж бүрдэнэ. Тухайлбал патент олгосноор хуулийн 47.2-д заасны дагуу патент эзэмшигчийн зөвшөөрөлгүй ашиглалтыг хориглох үйл ажиллагааг нарийвчлан хуульчилжээ. Ингэж зохицуулсан байхад патент олгох, олгохгүй нь тодорхой биш мэдүүлгийн үе шатанд шинэ бүтээлийг патент олгох хүртэлх хугацаанд түр хамгаалалтад авч, мэдүүлэг гаргагчид хуулийн 24.8-д заасны дагуу түүний зөвшөөрөлгүй шинэ бүтээлийг аливаа хэлбэрээр ашиглахыг “хориглох эрх” олгохоор тусгайлан шинээр хуульчилсан байна. Энэ зохицуулалт нь зүй тогтлын бус буюу патентаар олгогддог онцгой эрхийн мөн чанартай зөрчилдсөн, практикт хэрэгжүүлэх боломжгүй эрхийг мэдүүлэг гаргагчид эдлүүлэхээр шинээр зохицуулсан болохыг илтгэж байна. Энэ шинэ бүтээлийн ашиглалтыг хориглох эрхийг патентын онцгой эрхийн хүрээнд шинэ бүтээлд патент олгох шийдвэр гарсны дараа патент эзэмшигч гэх этгээд хэрэгжүүлэхээр хуульд заасан хүрээнд цаашид авч хэлэлцэнэ.

### Патент эзэмшигчийн эрх



Улсын Патентын Төв



МОНГОЛ УЛСЫН ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛЬ

Патентын эрхийн хүрээнд патентаар хамгаалагдсан шинэ бүтээлийн патент эзэмшигчийн эрхийг хамгаалж, түүний ашиглахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулдаг байна. Тухайлбал, хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оюуны өмчийн байгууллагад нийтэд мэдээлсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт эсэргүүцэл ирүүлээгүй бол патент олгохоор заасан. Патент олгосноор патент эзэмшигч нь түүний зөвшөөрөлгүй патентаар хамгаалагдсан шинэ бүтээлийн ашиглалтыг хориглох эрхтэй болдог. Шинэ бүтээлийн ашиглалтын тухайд патентаар хамгаалагдсан аргыг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэрэглэх болон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, худалдаалах, худалдаанд нийлүүлэх, импортоор оруулж ирэх зэргийг хамааруулдаг байна. Түүнчлэн патент эзэмшигч патент нь хүчинтэй байх тохиолдолд энэхүү эрхийг эдлэхээр зохицуулжээ. Үндсэндээ патент олгосны дараа онцгой эрхийг патент эзэмшигчид эдлүүлэхээр заасан байна. Патентаар олгогдох онцгой эрхийн тухайд патент эзэмшигчид аливаа хэлбэрээр ашиглахыг хориглох эрх олгодоггүй ажээ. Тухайлбал, хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу патент эзэмшигчийн эрхийг доорх тодорхой тохиолдлуудад хязгаарладаг. Үүнд:

- патент эзэмшигч өөрөө, эсхүл түүний зөвшөөрөлтэйгөөр бусад этгээд бараа бүтээгдэхүүнийг Монгол Улсын зах зээлд нэвтрүүлснээс хойш тухайн бараа бүтээгдэхүүнийг худалдах, худалдахаар санал болгох, эсхүл хэрэглэх;

- эрдэм шинжилгээ, сургалт, туршилтын ажилд хэрэглэх;

- Монгол Улсын нутаг дэвсгэрт түр орж ирсэн гадаад улсын тээврийн хэрэгсэлд хэрэглэх;

- ашиг олох зорилгогүйгээр хувийн хэрэгцээнд хэрэглэх;

- анхдагч огнооноос өмнө тухайн шийдлийг Монгол Улсад шударгаар ашиглаж байсан, эсхүл ашиглах бэлтгэлийг хангасан байсан бол.

Энэ эрхийн хязгаарлалтын хүрээнд патентаар хамгаалагдсан шинэ бүтээлийг ашигласан гэж тооцохгүй бөгөөд патент

эзэмшигчид олгосон онцгой эрх үйлчлэхгүй. Гэтэл дээрх мэдүүлэг гаргах эрхийг зохион бүтээгчээс шилжүүлэн авсан этгээдэд патентын мэдүүлгийг хайлтын тайлангийн хамт хэвлэхтэй зэрэгцэн хэвлэгдсэн шинэ бүтээлийг патент олгох хугацаанд түр хамгаалах, энэ түр хамгаалах хугацаанд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр шинэ бүтээлийг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглох хуулийн 24.8-ийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг хуулиар зохицуулаагүй, хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн зохицуулалт болохыг илтгэж байна. Улмаар патентын хууль тогтоомжид мэдүүлэг гаргагчийн эрх гэж илрэхгүй байхад патент эзэмшигчид эдлүүлэхээр заасан онцгой эрхээс үнэмлэхүй давуутай эрх мэдүүлэг гаргагчид олгохоор хуульчилсныг өөрчлөх шаардлага тулгарсан гэж үзэж байна.

Цаашилбал патентын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах буюу патент эзэмшигчийн эрхийг хангах, хэрэгжүүлэх бусад холбогдох хууль, тогтоомжоор ч мэдүүлэг гаргагчийн эрхийг хамгаалах талаар мөн зохицуулаагүй байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуульд патентаар хамгаалагдсан бүтээгдэхүүнийг эсхүл патентаар хамгаалагдсан аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг патент эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэсэн, зах зээлд нийлүүлсэн ... нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол ... төгрөгөөр торгоно гэж заажээ (Зөрчлийн тухай хууль, 2017). Патентын хуулийн зорилтын хүрээнд мэдүүлэг гаргагчийн эрхийг бус харин зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрхийг хамгаалахад чиглэж байх тул энэ 24.8 дахь хэсгийг хуульд шинээр оруулсныг зөвтгөх үндэслэл судалгаагаар олдсонгүй. Патентаар хамгаалагдсан шинэ бүтээлийг өмчлөх онцгой эрх Монгол Улсын Патентын тухай хуульд зааснаар патент эзэмшигчид хадгалагддаг байна. Энэхүү заалт нь патентын хуулиар зохицуулах суурь харилцаатай илт зөрчилдсөн зохицуулалт болсон байх тул бүхэлд нь өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна. Үүнтэй адил зохицуулалт хуулийн Дөрөвдүгээр бүлэг

Бүтээгдэхүүний загварын хамгаалалтын 37.8 дахь хэсэгт бүтээгдэхүүний загварт давтагдсан байгааг мөн хамааруулан өөрчлөх шаардлагатай.

### Түр эрх

Патентын хуулийн үйлчлэлийн хүрээнд патент олгосон шинэ бүтээлд тодорхой хугацаагаар олгодог онцгой эрхийг мэдүүлэг гаргагчид түр эдлүүлэхээр заасныг үндэсний патентын хууль тогтоомжийн хүрээнд болон олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд зохицуулаагүй байна. Зарим улсуудын хувьд, жишээ нь Америкийн Нэгдсэн Улсад (АНУ) патентын мэдүүлгээ урьдчилан байдлаар эхэлж гаргах боломжийг патентын хуулиараа түр мэдүүлэг буюу “provisional application”-н хүрээнд олгодог (Provisional Application for Patent, <https://www.uspto.gov/patents/basics/apply/provisional-application>). Түр мэдүүлэгт томъёоллыг заавал ирүүлэхийг шаардахгүй зэрэг хөнгөлөлт үзүүлэхийн зэрэгцээ түр мэдүүлэг байх хугацааг 12 сараар тогтоожээ. Түр мэдүүлэг гаргах нь онцгой эрх олгохтой холбоогүй бөгөөд өөрийн санаагаа хэрэгжүүлэх боломжтой байдлаар эхлэж оюуны өмчийн байгууллагад мэдүүлээд, дараа нь томъёолол болон бусад сайжруулалтыг оруулж мэдүүлгээ бүрэн засаж боловсруулаад оюуны өмчийн газар патентын мэдүүлэг мэдүүлэх боломжийг олгодог (De Penning & De Penning, The Ultimate Guide to Provisional Patents and Their Public Disclosure, 2024).

Түр эрх буюу “provisional right” гэдэг нэр томъёо патентын тогтолцоонд хэрэглэгддэг байх бөгөөд энэ түр эрх нь патент эзэмшигчийн эрхийг хангахад чиглэгддэг байна. Түр эрхийн тухайд шинэ бүтээлийн мэдүүлгийг хэвлэсэн хугацаанаас патент олгох хүртэлх хугацаанд патент эзэмшигчийн эрхийг хангах буюу энэ хугацаанд ашигласан этгээдээс зохих төлбөр авах эрхээр хангах тухай ойлголтын хүрээнд авч үздэг (LSD, 2025). Энд түр эрхийг патент эзэмшигч эдлэхийн тулд патент олгосон шинэ бүтээл нь хэвлэгдсэн патентын мэдүүлэгтэй яг адил байх шаардлагыг хангах шаардлагатай. Шинэ бүтээл нь ихэнхдээ

патентын мэдүүлгийг хэвлэх үед анх нийтэд дэлгэгддэг (Оюуны өмчийн газар, 2009). Ингэж нийтэд дэлгэгдэх нь шинэ бүтээлийг бусад этгээд мэдэж авах, улмаар шинэ бүтээлээр мэдүүлсэн шийдлийг ашиглан үйлдвэрлэл эрхлэх, зах зээлд нийлүүлэх, хэрэглэх зэрэг хохирол учруулдаг. Энэ асуудлыг патентын эрх зүйд патент эзэмшигчид түр эрх олгох замаар шийдвэрлэхийг зорьжээ. Түр эрхийг патент олгохоос өмнө патент эзэмшигчид бий болсон хохиролтой холбогдон маш ховор гардаг зөрчилд хамруулсан байх бөгөөд түр эрхийг патент олгосны дараа патент эзэмшигч зөрчлийн хохирлыг нөхөн барагдуулахаар хандах эрх гэж тодорхойлжээ (Brian V. Slater et.al., 2018).

Түр эрхийг патентын хуулиндаа Америкийн Нэгдсэн Улс (АНУ) хуульчилсан байх бөгөөд хуулийн 14 дүгээр бүлэгт патент олгох харилцааг зохицуулахдаа түр эрхийн хүрээнд патентын мэдүүлгийг хэвлэлд нийтэлсэн өдрөөс эхэлж патент олгосон өдөр хүртэлх хугацаанд патентын эрх эдлэхээр зааж, энэ хугацаанд аливаа этгээдээс патентын онцгой эрхийг зөрчсөн тохиолдолд зохих төлбөрийг авах эрхтэй гэж патентын эрхийн хугацааг тооцоход хамааруулан зохицуулжээ. Ингэхдээ түр эрхийг хэвлэгдсэн патентын мэдүүлэг нь патент олгосон шинэ бүтээлтэй яг ижил байх тохиолдолд эдлүүлэхээр хуульчилжээ (Patent laws, 35 U.S.C.154 (d)). Түр эрхийн тухай ойлголт нь шинэ ойлголт биш байх бөгөөд дэлхий дээр Европ, Японы зэрэг дэлхийн хэд хэдэн улсууд патентын тогтолцоондоо ямар нэг хэмжээгээр зохицуулсан байдаг бөгөөд түр эрхийн зохицуулалт нь хүлээгдэж буй патентын мэдүүлгүүдийг хэвлэхтэй нягт холбоотой заалт юм (Philippe Signore (2000)).

Эндээс патентын түр эрх гэдэг нь патент олгосон тохиолдолд патентын мэдүүлэг хэвлэгдэж нийтэд ил болсон хугацаанаас патент олгох хүртэлх хугацаанд патент эзэмшигчийн эрхийг хамгаалах буюу патентын эрхийг мэдүүлэг ил болж хэвлэгдсэн хугацаанаас эхэлж хангахаар зохицуулж, патентын эрхийн зөрчилд хамааруулж хариуцлага тооцох



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬЧЛАЛЫН  
УНДЭСНИЙ  
УНДЭСНИЙ  
УНДЭСНИЙ



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ

боломжоор хангасан хүрээнд тодорхойлох боломжтой байна. Ингэж патент эзэмшигчийн эрхийг шинэ бүтээлийг оюуны өмчийн байгууллага нийтэд дэлгэсэн үеэс хамгаалах эрх зүйн үндэсийг хууль тогтоомжийн хүрээнд бүрдүүлэх нь зохион бүтээх, шинийг санаачлах их үйлсийг дэмжихэд ихээхэн ач холбогдолтой. Практикт тулгарч байгаа энэ асуудлыг 2021 онд патентын хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулахдаа түр эрхийг мэдүүлэг гаргагчид хамааруулж, мэдүүлгийн шатанд хуульчилсан нь энэ олон улсад хэрэгжиж байгаа патент эзэмшигчийн эрхийг хангахад чиглэсэн түр эрхийн зохицуулалтын агуулга, мөн чанарт нийцэхгүй байна. Түр эрхийн зохицуулалтыг хуульчлахдаа АНУ нь дээр дурдсанчлан патентын эрхийн хугацааг тооцоход хамааруулсан байгааг анхаарах нь зүйтэй юм. Патентын онцгой эрхийг эдлэх хугацааг патентын мэдүүлэг хэвлэгдснээс тооцох хүрээнд түр эрхийн зохицуулалтыг хуульчлан өөрчлөх шаардлагатай. Үүнээс гадна түр эрхийн томьёолол, түр эрх эдлэх шалгуур нөхцлийг нарийвчлан судлаж, патентын хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатайг дээрх судалгааны дүнд олж тогтоолоо.

### Дүгнэлт, Санал

Мэдүүлэг гаргагчийн эрхийг хамгаалах асуудал патентын хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаардаггүй байна. Патент авахаар мэдүүлсэн шинэ бүтээл нь патентаар хамгаалагдсан тохиолдолд патент эзэмшигч патентаар олгогдох онцгой эрхийг эдлэх боломж бүрдэж, улмаар патентаар хамгаалагдсан шинэ бүтээлийг бусад этгээд зөвшөөрөлгүй ашиглахаас тодорхой тохиолдлуудад хамгаалуулах эрхтэй болдог ажээ. Гэтэл патент олгоогүй, тэртүсмаа патент олгох эсэх нь тодорхойгүй мэдүүлгийн шатанд байгаа шинэ бүтээлийг түр хамгаалах талаар тус хуулийн 24.8-д зохицуулснаас гадна патент эзэмшигчид хуульд заасан хүрээнд эдлүүлэхээр заасан онцгой эрхээс илүү

хүчин чадалтай үйлчлэх түр эрхийг мэдүүлэг гаргагчид олгосон байна. Хуулийн 24.8-д заасны дагуу мэдүүлэг гаргагч шинэ бүтээлийг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглох эрх зүйн үндэс бүрдээгүй, энэ хуулийн хэсэг нь бүхэлдээ хуулийн патентын эрх, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах Долдугаар бүлэгтэй зөрчилдсөн, патентын эрхийн хэрэгжилтийг хангах бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдаагүй байна. Иймд патентын хууль тогтоомжоор зохицуулахыг зорьсон суурь харилцаатай илт зөрчилдсөн энэхүү хуулийн хэсгийг өөрчлөх шаардлагатай гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Хуулийн энэ хэсэгт шинээр зохицуулсан мэдүүлэг гаргагчид олгосон “түр хамгаалалт”-ын талаар судлахад “provisional right” буюу “түр эрх” гэдэг нэр томьёоны хүрээнд патентын эрх зүйн тогтолцоотой зарим улсын хууль тогтоомжид нэвтэрч хэрэглэгдсээр иржээ. Түр эрхийн зохицуулалтыг патент эзэмшигчийн эрхийг хуульд заасны дагуу хангах үндсэн зарчимд нийцүүлэн зохицуулдаг байна. Өөрөөр хэлбэл, түр эрхийн зохицуулалт нь патентаар олгогдох онцгой эрхтэй холбогдон зохицуулагддаг байх бөгөөд энэхүү онцгой эрх эдлэх хугацааг патентын мэдүүлгийг оюуны өмчийн газар хэвлэснээс эхэлж тооцох хүрээнд авч үзэж патент эзэмшигчийн эрхийг хамгаалахад чиглэдэг байна. Ингэхдээ түр эрхийг хэрэгжүүлэх шалгуур нөхцлийг хуулиар нарийвчлан зохицуулж иржээ. Хэрвээ түр эрхийг дээрх агуулгын хүрээнд патентын хуульд шинээр хуульчилсан бол мэдүүлгийн шатанд патентын мэдүүлэг хэвлэхтэй зэрэгцэн зохицуулсан нь хууль зүйн үндэслэлгүй байдлыг бий болгоход хүргэсэн байна. Түр эрхийн зохицуулалтыг патентын эрхийн хүрээнд нарийвчлан хуульчилж өгөх шаардлагатай. Цаашид түр эрхийн зохицуулалтыг боловсронгуй болгосноор патент эзэмшигч патентын мэдүүлгийг хэвлэсэн хугацаанаас патент олгох хүртэлх хугацаанд эрхээ хангуулах буюу түүний шинэ бүтээлийг ашигласан этгээдээс зохих төлбөр авах эрх зүйн үндэс бүрдэх ач

холбогдолтой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

### Эх сурвалж

Монгол Улсын Их Хурал (2021). Патентын тухай хууль, Улаанбаатар: Төрийн мэдээлэл эмхэтгэл, №34.

Монгол Улсын Их Хурал (2017). Зөрчлийн тухай хууль, Улаанбаатар: Төрийн мэдээлэл эмхэтгэл, №24.

Намжил, З. (2000). *Патент-эрх зүйн оньс*. Улаанбаатар.

Оюуны өмчийн газар. (2009). *Ирээдүйг бүтээхүй, жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан патентын танилцуулга*, (Орч.; Одгэрэл, Б.)

Чинбат, Н. (2014). *Иргэний эрх зүй лекцийн товчоон* (ерөнхий анги). Улаанбаатар.

Brian V. Slater and John P. Dillon, (2018). *Preserving Provisional Rights for Pre-Issuance Patent Damages*, Section of

Intellectual Property Law Landslide January/February 2018 Vol. 10 No.3 <https://www.hsfkramer.com/kl-pdfs/4/3/43719.pdf>

De Penning & De Penning. (2024). *The Ultimate Guide to Provisional Patents and Their Public Disclosure*, <https://depenning.com/blog/the-ultimate-guide-to-provisional-patents-and-their-public-disclosure/>

LSD. (2025). *Provisional right*, <https://www.lsd.law/define/provisional-right> Patent laws, 35 U.S.C.154 (d)

Philippe Signore, (2000). *The New Provisional Rights Provision*, J. Pat. & Trademark Off. Soc'y, volume 742, p.752-54.

USPTO. (2025). *Provisional Application for Patent*, <https://www.uspto.gov/patents/basics/apply/provisional-application>



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ  
ЭРХ  
ЗҮЙН  
УНДГАР  
УНИВЕРСИТЕТ